

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2024/122/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Дундговь аймаг  
2024 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439  
Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Наранцацрал  
Утас: 70592225  
Цахим хаяг: [Narantsatsralkh@audit.gov.mn](mailto:Narantsatsralkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Ихбаяр  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Ikhbayard@audit.gov.mn](mailto:Ikhbayard@audit.gov.mn)

Аудитор: Д.Оюунбат  
Утас: 70592208  
Цахим хаяг: [oyunbatdorjkhanda@gmail.com](mailto:oyunbatdorjkhanda@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	1
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dandgovi@audit.gov.mn

2024-02-26

№

58

танай

-ны №

-т

ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА С.ОТГОНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.4-т заасны дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар цалингийн зардлаас албан хаагчдад 7,200.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.5-т /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 1.3-т /Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгоход шаардагдах хөрөнгийг тухайн байгууллага төсөвтөө тусгаж санхүүжүүлнэ/, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т /урамшуулал цалин хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл суутгагдахгүй, нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшуулал хамаарахгүй/ гэж заасныг тус тус зөрчсөн байна. Аудитаар илэрсэн нийт залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 46.4 мянган төгрөгөөр их байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад 2022 онд тус байгууллага нь орон нутгийн өмчөөс улсын өмчид шилжиж өмчлөлийн хэлбэр өөрчлөгдсөнтэй холбоотой үр дүнгийн тайлангийн өмнөх он зөрүүтэй байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### **Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төв нь байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилт, 37 арга хэмжээ тусгаж хэрэгжилтийг хангаж ажилласнаар сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт 88.6 хувьтай байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>323,706,869.45</b>	<b>329,805,213.61</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>160,907,013.63</b>	<b>184,488,302.05</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>160,907,013.63</b>	<b>184,488,302.05</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>160,907,013.63</b>	<b>184,488,302.05</b>
31211	Төрийн сангийн харилцах	160,907,013.63	184,488,302.05
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0</b>	<b>11,254,528.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0	11,254,528.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>162,799,855.82</b>	<b>134,062,383.56</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>102,489,800.63</b>	<b>67,435,741.38</b>
35110	Тусгай зориулалттай материал	15,100,093.69	24,456,069.88
35130	Эм боох материал	87,389,706.94	42,979,671.50
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>59,020,055.19</b>	<b>65,156,642.18</b>
35410	Бичиг хэргийн материал	2,015,600.00	1,440,000.00
35420	Аж ахуйн материал	34,621,722.19	38,903,129.18
35440	Түлш, шатах тослох материал	202,510.00	604,900.00
35450	Барилгын засварын материал	2,339,800.00	3,851,200.00
35460	Хүнсний материал	3,506,673.00	2,738,813.00
35470	Бусад хангамжийн материал	16,333,750.00	17,618,600.00
35600	Мал амьтад	1,290,000.00	1,470,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>875,986,689.60</b>	<b>1,187,551,099.29</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>875,986,689.60</b>	<b>1,187,551,099.29</b>
39100	Газар	0	0
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>863,356,689.60</b>	<b>1,174,921,099.29</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	714,905,443.00	1,024,535,235.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	-105,703,925.18	-136,495,926.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,980,000.00	60,780,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-19,398,055.59	-26,044,722.27
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	299,944,374.65	317,579,086.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	-92,479,648.96	-88,853,347.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,198,840.00	33,618,390.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,090,338.32	-10,197,617.50
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>12,630,000.00</b>	<b>12,630,000.00</b>
39301	Програм хангамж	659,275.00	659,275.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-659,275.00	-659,275.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,630,000.00	12,630,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,199,693,559.05</b>	<b>1,517,356,312.90</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>14,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>14,000.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0</b>	<b>14,000.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	14,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,199,693,559.05</b>	<b>1,517,342,312.90</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,199,693,559.05</b>	<b>1,517,342,312.90</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	180,920,980.80	180,920,980.80
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0	0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	180,920,980.80	180,920,980.80
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>809,287,207.39</b>	<b>1,126,935,961.24</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-169,796,487.26	809,287,207.39
51220	Тайлант үеийн үр дүн	979,083,694.65	317,648,753.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	209,485,370.86	209,485,370.86
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,199,693,559.05</b>	<b>1,517,356,312.90</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,696,864,427.36</b>	<b>1,033,591,172.42</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,105,211,137.36</b>	<b>391,664,486.68</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,105,211,137.36</b>	<b>391,664,486.68</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>7,204,123.00</b>	<b>1,375,258.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,204,123.00	1,375,258.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	896,298,133.43	367,386,311.70
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	201,708,880.93	22,902,916.98
<b>121</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>591,653,290.00</b>	<b>641,926,685.74</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>28,072,500.00</b>	<b>35,584,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,072,500.00	35,584,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>563,580,790.00</b>	<b>606,342,485.74</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	563,580,790.00	606,342,485.74
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>717,780,732.71</b>	<b>715,360,379.75</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>717,780,732.71</b>	<b>715,360,379.75</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>716,989,430.84</b>	<b>708,575,804.03</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>323,941,812.00</b>	<b>365,797,428.53</b>
210101	Үндсэн цалин	223,839,995.80	245,895,681.53
210102	Нэмэгдэл	69,303,876.00	90,394,044.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,669,363.00	3,608,000.00
210104	Урамшуулал	27,128,577.20	25,899,703.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>40,334,892.37</b>	<b>45,594,721.49</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,043,719.37	31,980,742.49
210202	Тэтгэмжийн даатгал	2,914,348.00	3,073,283.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,976,966.00	3,612,195.00
210204	Ажилгүйдлийн даатгал	568,138.00	605,720.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,831,721.00	6,322,781.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,701,198.13</b>	<b>26,322,564.28</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,224,198.13	4,124,816.28
210302	Түлш, халаалт	22,477,000.00	21,197,748.00
210303	Цэвэр, бохир ус	0	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>52,183,599.02</b>	<b>63,417,959.51</b>
210401	Бичиг хэрэг	4,458,780.00	3,042,600.00
210402	Тээвэр, шатахуун	18,629,220.00	17,257,745.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	981,900.00	917,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	707,200.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,383,178.00	7,784,250.00
210408	Бараа материал акталсны зардал	10,023,321.02	34,266,264.21
210409	Бараа материал шилжүүлсний зардал	0	150,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>128,065,741.91</b>	<b>75,165,570.62</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	117,516,862.91	67,201,660.62
210502	Хоол, хүнс	10,548,879.00	7,963,910.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>48,913,400.00</b>	<b>19,124,850.00</b>
210604	Урсгал засвар	48,913,400.00	19,124,850.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,944,000.00</b>	<b>10,351,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,944,000.00	10,351,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,420,910.00</b>	<b>2,342,444.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	850,000.00	739,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,210.00	97,144.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	23,400.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	360,000.00
210807	Газрын төлбөр	126,300.00	126,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>91,483,877.41</b>	<b>100,459,265.60</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,298,433.58	4,276,112.41
210903	Үндсэн хөрөнгийн элэглэл, хороглол	85,185,443.83	96,183,153.19

Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	791,301.87	6,784,575.72
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	791,301.87	6,784,575.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	979,083,694.65	318,230,792.67
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	582,038.82
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	582,038.82
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	979,083,694.65	317,648,753.85

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН /төгрөгөөр/
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	819,467,277.40	632,047,415.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,726,287.40	1,375,258.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,726,287.40	1,375,258.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,726,287.40	1,375,258.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,982,770.00	1,375,258.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	7,743,517.40	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	809,740,990.00	630,672,157.74
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,072,500.00	35,584,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,072,500.00	35,584,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	781,668,490.00	595,087,957.74
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	781,668,490.00	595,087,957.74
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	593,686,263.77	567,522,837.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	593,686,263.77	567,522,837.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	592,894,961.90	560,738,261.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	323,941,812.00	365,783,428.53
210101	Үндсэн цалин	223,839,995.80	245,881,681.53
210102	Нэмэгдэл	69,303,876.00	90,394,044.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,669,363.00	3,608,000.00
210104	Урамшуулал	27,128,577.20	25,899,703.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,334,892.37	45,594,721.49
210201	Тэтгэврийн даатгал	28,043,719.37	31,980,742.49
210202	Тэтгэмжийн даатгал	2,914,348.00	3,073,283.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,976,966.00	3,612,195.00
210204	Ажилгүйдлийн даатгал	568,138.00	605,720.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,831,721.00	6,322,781.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,701,198.13	26,322,564.28
210301	Гэрэл, цахилгаан	3,224,198.13	4,124,816.28
210302	Түлш, халаалт	22,477,000.00	21,197,748.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,391,988.00	35,872,385.30
210401	Бичиг хэрэг	5,402,880.00	2,467,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,813,190.00	17,558,935.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,058,900.00	917,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	952,200.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,164,818.00	14,929,350.00
2105	Нормативт зардал	96,519,161.40	51,384,048.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	83,081,261.40	41,893,398.00
210502	Хоол, хүнс	11,342,900.00	7,196,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,095,000.00	2,294,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,641,000.00	21,046,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	410,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,250,000.00	0.00
210604	Урсгал засвар	49,391,000.00	20,636,250.00
2107	Томилолт, зочны зардал	4,944,000.00	10,351,000.00
210702	Дотоод албан томилолт	4,944,000.00	10,351,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	1,420,910.00	2,342,444.00

Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	850,000.00	739,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,210.00	97,144.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	23,400.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	360,000.00
210807	Газрын төлбөр	126,300.00	126,300.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0.00</b>	<b>2,041,420.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,041,420.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>791,301.87</b>	<b>6,784,575.72</b>
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>791,301.87</b>	<b>6,784,575.72</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	791,301.87	6,784,575.72
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>225,781,013.63</b>	<b>64,524,578.42</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>64,874,000.00</b>	<b>40,943,290.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>64,874,000.00</b>	<b>40,943,290.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>64,874,000.00</b>	<b>40,943,290.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	64,874,000.00	40,943,290.00
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-64,874,000.00</b>	<b>-40,943,290.00</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>160,907,013.63</b>	<b>23,581,288.42</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	160,907,013.63
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	160,907,013.63	184,488,302.05

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	180,920,980.80	209,485,370.86	-169,796,487.26	220,609,864.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	180,920,980.80	209,485,370.86	-169,796,487.26	220,609,864.40
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	979,083,694.65	979,083,694.65
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	180,920,980.80	209,485,370.86	809,287,207.39	1,199,693,559.05
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	180,920,980.80	209,485,370.86	809,287,207.39	1,199,693,559.05
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	180,920,980.80	209,485,370.86	809,287,207.39	1,199,693,559.05
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	317,648,753.85	317,648,753.85
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	180,920,980.80	209,485,370.86	1,126,935,961.24	1,517,342,312.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>805,020,300.00</b>	<b>572,471,007.32</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>805,020,300.00</b>	<b>572,471,007.32</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>805,020,300.00</b>	<b>572,471,007.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>457,034,600.00</b>	<b>365,783,428.53</b>
210101	Үндсэн цалин	269,009,900.00	245,881,681.53
210102	Нэмэгдэл	123,931,000.00	90,394,044.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,969,000.00	3,608,000.00
210104	Урамшуулал	60,124,700.00	25,899,703.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>57,129,300.00</b>	<b>45,594,721.49</b>
210201	Тэтгэврийн даатгал	38,847,900.00	31,980,742.49
210202	Тэтгэмжийн даатгал	4,570,300.00	3,073,283.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,656,300.00	3,612,195.00
210204	Ажилгүйдлийн даатгал	914,100.00	605,720.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,140,700.00	6,322,781.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>63,986,100.00</b>	<b>35,872,385.30</b>
210401	Бичиг хэрэг	9,000,300.00	2,467,000.00
210402	Тээвэр, шатахуун	30,737,400.00	17,558,935.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,750,000.00	917,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,498,100.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,000,300.00	14,929,350.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>101,777,100.00</b>	<b>51,384,048.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,422,300.00	41,893,398.00
210502	Хоол, хүнс	18,354,800.00	7,196,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,000,000.00	2,294,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>93,250,900.00</b>	<b>59,512,480.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,000,300.00	40,813,290.00
210602	Тавилга	3,750,300.00	540,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,500,000.00	0
210604	Урсгал засвар	40,000,300.00	18,159,190.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,200,000.00</b>	<b>10,351,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	13,200,000.00	10,351,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,570,000.00</b>	<b>2,342,444.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,500,000.00	739,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	97,144.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	360,000.00
210807	Газрын төлбөр	200,000.00	126,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,072,300.00</b>	<b>1,630,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,072,300.00	1,630,500.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>805,020,300.00</b>	<b>596,463,215.74</b>
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>649,221,300.00</b>	<b>595,087,957.74</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	649,221,300.00	595,087,957.74
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>155,799,000.00</b>	<b>1,375,258.00</b>
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	113,400.00	1,375,258.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	155,685,600.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	155,685,660.63
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	179,677,869.05

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,238.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 38.0 мянган төгрөгийн алдааг залруулж, зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 7,200.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 2 заалт бүхий зөвлөмжийг хүргүүллээ.

#### *Залруулсан алдаа*

Томилолтын зардал, хоолны хөнгөлөлтийг 38.0 мянган төгрөгөөр давхардуулан олгосон.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын 2.2.3, Төсвийн тухай хуулийн 6.4.1-т тус тус заасныг, мөн үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### *Залруулаагүй алдаа:*

Аудитаар нийт 7,200.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 7,200.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 2 заалт зөвлөмжийг хүргүүллээ.

#### **3.1 Албан шаардлага**

3.2.1 Цалингийн зардлаас албан хаагчдад 7,200.0 мянган төгрөгийн түлш, халаалтын хөнгөлөлт олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/ гэж заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг;

3.2.2 Ажил хавсран гүйцэтгэсэн албан хаагчдын хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, хавсран гүйцэтгэсэн ажлын тайланг үнэлээгүй, цалинг 100 хувиар тогтоож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-т /*байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох*/, Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-т /*Энэ хуулийн 49.1-д зааснаас гадна ажил үүргийн онцлогтой нь холбоотойгоор эд хөрөнгийн хариуцлагын, нууцын, сургалтын, үл өрсөлдөх зэрэг нэмэлт нөхцөлийг харилцан тохиролцож хөдөлмөрийн гэрээнд тусгах, эсхүл эдгээр асуудлаар хөдөлмөрийн гэрээнд дагалдах тусгайлсан гэрээ байгуулж болно*/, 56 дугаар зүйлийн 56.2-т /*Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно*/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг;

3.2.3 Байгууллагын дарга өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргаж, хөтлөөгүй.

Энэ нь Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т /*Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй байх*/, 6 дугаар зүйлийн

6.5-д /Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ/, 11 дүгээр зүйлийн 11.1-т /Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно/, 14 дүгээр зүйлийн 14.2-т /Албан тушаалтан албан үүргэтэй нь шууд ба шууд бусаар холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бусад этгээдийн өмнө төлөөлөхийг хориглоно/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг;

3.2.4 Улс төрийн албан тушаалтан буюу багийн Засаг даргаар нягтлан бодогчийн үүргийг хавсран гүйцэтгүүлсэн.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т/улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх/, 7.1.7-д /ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

### **5.3 Зөвлөмж**

5.3.1 Ажилчдын нийгмийн даатгалын шимтгэл тайлагналтай холбоотой асуудал:

#### Илрүүлэлт:

Илүү цагийн хөлсийг үндсэн цалингаас тооцдог, шөнийн цагаар ажилласан ажилтнуудыг нөхөн амраасан боловч шөнийн цагийн хөлс олгодог, нэмэгдэл хөлсийг хууль, журмын дагуу бодоогүй. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1-т /Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно/ 109.3-т /Шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно/, Эрүүл мэндийн салбарын 2022-2023 оны хамтын хэлэлцээрийн 3.4-т /Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу шөнийн цаг ажилласны нэмэгдэл хөлсийг тооцож олгоно/ тус тус заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын хэлтэстэй тооцоо нийлж, баталгаажуулан, зөрчлийг арилгах, хэрэгжилтийг хангаж, хариуг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт ирүүлэх

3.3.2 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

Шилэн дансанд байршуулвал зохих нийт 30 мэдээллээс 71.5 сая төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй, 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, хуулийн хэрэгжилт 86.1 хувьтай.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т /Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ/, 6.4-т /Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн

байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, хариуг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт ирүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
							Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Томилолтын зардал, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон.	1	38.0			1	38.0	1	38.0				
<b>ДҮН</b>	<b>1</b>	<b>38.0</b>			<b>1</b>	<b>38.0</b>	<b>1</b>	<b>38.0</b>				

/мянган төгрөгөөр/

2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардлаас албан хаагчдад түлшний хөнгөлөлт олгосон.	1	7200.0			1	7200.0						
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>7200.0</b>			<b>1</b>	<b>7200.0</b>						

/мянган төгрөгөөр/

2. Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

/мянган төгрөгөөр/

Хавсран гүйцэтгэж байгаа ажил үүргийг Хөдөлмөрийн гэрээний хавсралтад тусгаж, тайлан, гүйцэтгэлийг үндэслэн цалин урамшуулал олгож байх ба холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;	1	0	1	0				
Байгууллагын дарга өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргахдаа зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргаж, хөтлөөгүй байна.	1	0	1	0				
Илүү цагийн нэмэгдлийг үндсэн цалингаас тооцдог, шөнийн цагаар ажилласан ажилтнуудыг нөхөн амраасан боловч шөнийн цагийн нэмэгдэл олгодог, нэмэгдлийг хууль, журмын дагуу бодож олгоогүй.	1	0		1	0			
Шилэн дансанд байршуулвал зохих нийт 30 мэдээллээс 71.5 сая төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй, 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, хуулийн хэрэгжилт 86.1 хувьтай.	1	0		1	0			
<b>Нийт дүн</b>	<b>4</b>		<b>2</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>0</b>	